



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХЭРГИЙН САЙД

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 7а, Утас: 26 21 35,
Факс: (976-11) 32 21 27, E-mail: info@mfa.gov.mn,
http://www.mfa.gov.mn

2015.04.08 № 01/1780
танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БОЛДБААТАР ТАНАА


Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт гадаад бодлогын талаар дэвшүүлсэн зорилтууд болон ГХЯ-ны 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр тус яамнаас 3 дугаар сард хийж гүйцэтгэсэн ажлын тойм болон 4 дүгээр сард хийж гүйцэтгэх ажлын тоймыг хавсралтаар хүргүүлж байна.

УИХ-ын гишүүдэд танилцуулахыг хүсье.

Хавсралт: ... хуудас

Хувийг: УИХ-ын АБГББХ-ны дарга
Ж.Энхбаяр танаа

САЙД



Л.ПҮРЭВСҮРЭН

0000001053

ГХЯ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2015 ОНЫ 3 ДУГААР САРЫН ТОЙМ МЭДЭЭ

Нэг. Хоёр хөрштэй харилцах чиглэлээр

- ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины Монгол Улсад 2014 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр Монгол Улсад хийсэн ажлын айлчлалын үеэр манай талаас гардуулсан Санамж бичиг (Памятная записка)-ийн хэрэгжилтийн явц, цаашид авах арга хэмжээний талаар дотоодын албаны хүмүүстэй уулзалт зохион байгуулав. ОХУ-ын Ерөнхийлөгчийн ажлын айлчлалын дүнгээр баталсан ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хэсгийг шинэчлэх саналыг ЗГХЭГ-т хүргүүлэв.
- БНХАУ-ын даргын айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний явцын талаарх яамдын саналыг нэгтгэж биелэлтийг эцэслэв.
- УИХ-ын даргын БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулахаар УИХ-ын Тамгын газарт хүргүүлэв.
- ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын дарга С.Е.Нарышкины Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын дүнг Засгийн газарт танилцуулав.
- Монгол Улс, ОХУ-ын хооронд Стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн төслийг тохиролцох хамтарсан ажлын хэсгийн хоёрдугаар хуралдааныг ГХЯ-нд зохион байгуулав.
- Гадаад хэргийн сайдын БНХАУ-д хийх албан ёсны айлчлалын бэлтгэлийг хангаж хэрэгжүүлэв.
- Гадаад хэргийн дэд сайд тэргүүтэй төлөөлөгчид энэ сарын 23-ны өдөр Бээжин хотноо болсон Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Гадаад хэргийн дэд сайд нарын түвшний хоёрдугаар зөвлөлдөх уулзалтад оролцов.

Хоёр. Бусад улс, олон улсын байгууллагын чиглэлээр

- Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 3 дугаар сарын 3-4-нд ХБНГУ-д ажлын айлчлал хийж, энэ үеэрээ ИТБ-Берлин арга хэмжээний нээлтэд оролцож үг хэлсэн. Айлчлалын хүрээнд Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Холбооны Ерөнхийлөгч И.Гаук, Холбооны канцлер А.Меркель нартай тус тус уулзаж, Монгол, Германы бизнес уулзалтад оролцов.
- УИХ-ын дарга З.Энхболд 3 дугаар сарын 14-18-нд ХБНГУ-д, 18-21-нд БНПУ-д албан ёсны айлчлал тус тус хийв. Айлчлалын бэлтгэлийг хангаж ажиллав.
- Уул уурхайн сайд Р.Жигжид тэргүүтэй төлөөлөгчид Канадын хайгуулч, олборлогчдын олон улсын чуулга уулзалтад оролцоход дэмжлэг үзүүлж ажиллав. Энэ үеэр Уул, уурхайн сайд Р.Жигжид Канадын Парламентын Нийтийн танхимын гишүүн, уул уурхай эрхэлсэн парламентын Төрийн нарийн бичгийн дарга Келли Блок нар Монгол Улсын Уул уурхайн яам, Канад Улсын Байгалийн нөөцийн яам хоорондын “Эрдэс баялаг, металлын салбарын тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд Торонто хотноо гарын үсэг зурав.
- Хөдөлмөрийн сайд С.Чинзоригийн Унгар Улсад хийх ажлын айлчлалын бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлж ажиллав.

- УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатарын БН Чех Улсад 3 дугаар сарын 14-18-нд хийсэн айлчлалын бэлтгэл ажилд зохих дэмжлэг үзүүлж ажиллав.
- Монгол Улсын Шадар сайд У. Хүрэлсүх тэргүүтэй төлөөлөгчид Япон Улсын Сендай хотноо 3 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд Гамшгийн эрсдлийг бууруулах НҮБ-ын бага хуралд оролцов.
- Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн, Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Т.Шимизү нар Япон Улсын Засгийн газрын Соёлын буцалтгүй тусламжийн хүрээнд “Монголын Үндэсний музейн үзмэрийн хадгалалтын тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх тухай хоёр орны Засгийн газар хооронд солилцох Ноот бичигт 3 дугаар сарын 11-ны өдөр гарын үсэг зурав.
- Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн Япон Улсад хийсэн ажлын айлчлалын дүнг Засгийн газрын хуралдаан, ҮАБЗ-өөр хэлэлцүүлж, айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулав.
- Монгол Улс, БНСУ-ын Засгийн газар хоорондын Хамтарсан хорооны анхдугаар хуралдаан 3 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулав.
- Сингапур Улсын Ерөнхий сайд асан Ли Кван Ю таалал төгссөнтэй холбогдуулан Салах ёс гүйцэтгэх ёслолын арга хэмжээнд Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн оролцов. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Ерөнхий сайд Ч.Сайханбилэг нараас тус улсын Ерөнхийлөгч Тони Тан Кенг Яам, Ерөнхий сайд Ли Хсиен Лүүнг нарт эмгэнэлийн захидал хүргүүлэв.
- Мьянмарын Холбооны Нэгдсэн Улсын Ерөнхийлөгчийн зөвлөхүүд 3 дугаар сарын 18-22-ны өдрүүдэд Монгол Улсад айлчлав. Айлчлалын үеэр төлөөлөгчид Монгол Улсын Ерөнхийлөгчид бараалхаж, ЕТГ-ын дарга, Үндсэн хуулийн цэцийн дарга, Сонгуулийн Ерөнхий хорооны дарга нартай уулзаж Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөхүүдтэй дугуй ширээний уулзалт хийв. Төлөөлөгчдөд Гадаад хэргийн сайд оройн зоог барив.
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн ажлын хэсгийн ээлжит 22 дугаар хуралдаанаар Монгол Улс дахь хүний төлөв байдлын талаарх Үндэсний хоёрдугаар илтгэлийг хэлэлцүүлэн хамгаалах үеэр төлөөлөгчдийн баримтлах удирдамжийн төслийг боловсруулав.
- Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн Женев хотноо 3 дугаар сарын 4-6-ны өдрүүдэд ажиллаж, НҮБ-ын Зэвсэг хураах бага хурал, НҮБ-ын ХЭЗ-ийн чуулган, АОХН-ийн Удирдах зөвлөлийн хурлуудад оролцов.
- Гадаад хэргийн дэд сайд Н.Оюундарь НҮБ-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлахын эсрэг конвенцийн “Эмэгтэйчүүдийн аж байдлын комисс”-ын 59 дүгээр чуулганд оролцов.
- ЕАБХАБ-ын Мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх төвтэй хамтран ЕАБХАБ-ын Цэрэг-улс төрийн мөрдлөгийн дүрмийн асуудлаарх бүс нутгийн бага хурлыг 3 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулав.
- ЕАБХАБ-ын Үндэстэн дамнасан аюул заналхийлэлтэй тэмцэх албаны Хилийн аюулгүй байдал, менежментийн газартай хамтран 2015 оны 3 дугаар сарын 2-6-ны өдрүүдэд Хууль сахиулахын их сургууль дээр “Хилийн

аюулгүй байдал ба менежмент дэх эмэгтэйчүүд – Өнөөгийн болон ирээдүйн манлайлагчид” сэдэвт сургалтын дугуй ширээний уулзалтыг зохион байгуулав.

- “НҮБ-аас Монгол Улсад 2012-2016 онд үзүүлэх хөгжлийн тусламжийн хүрээ” баримт бичгийн хэрэгжилт болон 2014 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх хурлыг зохион байгуулав.
- “Онлайн эрх чөлөө” эвслийн 5 дугаар бага хурлын бэлтгэл ажлын талаар Улаанбаатар дахь ЭСЯ-ны төлөөлөгчдөд мэдээлэл хийв. Мөн мэдээлэл, харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн компаниудын төлөөлөгчдийг хүлээн авч уулзан, мэдээлэл хийв. Friends of Chair бүлгийн conference-call болон ажлын уулзалтуудыг хийв. Бага хурлын хэлэлцэх асуудлууд, салбар хурлуудаар хэлэлцэх 40 орчим илтгэлийн нэрс тодров.
- Хууль зүйн яам, ЕАБХАБ-ын Үндэстэн дамнасан аюул заналхийлэлтэй тэмцэх албаны хамтарсан дугуй ширээний уулзалтад оролцож, ЕАБХАБ-тай цаашид хамтран ажиллах чиглэлээр санал солилцов.
- НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлд илгээх үндэсний илтгэлийн хэлэлцүүлгийг зохион байгуулав.
- Евразийн эдийн засгийн комиссын Зөвлөлийн интеграци, макро эдийн засгийн асуудал хариуцсан гишүүн Т.Д.Валоваягийн Монгол Улсад хийсэн айлчлалын бэлтгэл ажилд оролцов.

Гурав. Гадаад сурталчилгааны чиглэлээр:

- БСШУЯ, ЮНЕСКО, Дипломат академи, Соёлын өвийн төв, СУИС, музей, судалгааны ТББ зэрэг 19 байгууллагын 30 гаруй төлөөлөгч оролцсон “Монголын соёлын өв-гадаад сурталчилгаа” бодлогын хэлэлцүүлгийг зохион явууллаа.
- Гадаад улсуудтай дипломат харилцаа тогтоосны болон тэгш ойг тэмдэглэх цаглабар гарган, зохион байгуулах арга хэмжээг нэгдсэн зохион байгуулалтаар хангах, уялдуулахаар төлөвлөн ажиллаж байна. Ойг тэмдэглэх ажлыг хэрэгжүүлж, фото зургийн үзэсгэлэн, эрдэм шинжилгээний бага хурал, монголын соёлын өдрүүдийг тус тус зохион байгуулж хэвлэлээр сурталчлах ажлыг хэрэгжүүлж байна.
- Хулгайлагдсан болон хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн талаар ЮНИДРОИТ-ын 1995 оны конвенцид нэгдэх асуудлаар ЮНЕСКО, БСШУЯ, ГХЯ харилцан мэдээлэл солилцож ажиллаж байна.
- Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улстай дипломат харилцаа тогтоосны 25 жилийн ойн хүрээнд Сөүл хотноо 2015 оны 3 дугаар сарын 18-28-ны өдрүүдэд гэрэл зургийн үзэсгэлэн, Улаанбаатар хотноо шинжлэх ухааны бага хурал зохион байгуулав.

Дөрөв. Консулын харилцааны чиглэлээр

- “Хилийн чанадад байгаа монгол улсын иргэдэд туслах сан”-гийн ээлжит 29 дүгээр хуралдааныг зохион байгуулав. Энэ удаагийн хурлаар 29 өргөдөл,

хүсэлтийг хэлэлцүүлэн 43.260.101 төгрөгийн тусламж олгох шийдвэр гаргав.

- Швейцарын Холбооны Улсаас тусгай нислэгээр албадан буцаагдан ирж байгаа 11 иргэнийг хүлээн авах ажлыг ИХШХЕГ, УБЕГ болон Швейцарын Холбооны Улсын ЕКГ-тай хамтран зохион байгуулав.

Тав. 4 дүгээр сард хийхээр төлөвлөж буй тоймтой ажил

- Энэтхэг Улсын Ерөнхий сайд Модигийн Монгол Улсад хийх айлчлалын бэлтгэлийг хангаж ажиллах,
- Унгар Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсад хийх албан ёсны айлчлалыг зохион байгуулах,
- Турк Улсын Гадаад хэргийн сайдын Монгол Улсад хийх албан ёсны айлчлалыг зохион байгуулах,
- Гадаад хэргийн сайд Л. Пүрэвсүрэн Индонезийн Жакартад 4 дүгээр сарын 19-24-нд Зүүн Азийн асуудлаарх Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтад болон Бандунгийн бага хурлын 60 жилийн ойн арга хэмжээнд оролцох,
- Монгол, Хятадын ЗГХК-ын монголын талын ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулах,
- Эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангаж хэрэгжүүлэх,
- НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлд Монгол Улсын үндэсний сайн дурын илтгэлийг хүргүүлэх,
- Онлайн эрх чөлөө “ эвслийн сайд нарын 5 дугаар бага хуралд үргэлжлүүлэн бэлтгэх,
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, төслийг боловсруулах, цахим визийг нэвтрүүлэх чиглэлээр Хууль зүйн яам, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газартай хамтарч ажиллах,
- Цахим энгийн гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэр чиглэлээр Хууль зүйн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтарч ажиллах,
- ХБНГУ болон Итали Улсад энэ оны 5, 6 дугаар сард болох олон улсын үзэсгэлэнд Монгол Улс оролцох бэлтгэл ажлыг хангах зэрэг болно.

---oOo---